



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/88

Өргөн

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, яутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Сумын шилдэг хот айл", "Сумын аварга малчин" шалгаруулах журмыг шинэчлэн батлуулахыг Засаг даргын дэргэдэх удирдлагын багт даалгасугай.

2."Сумын шилдэг хот айл" шалгаруулах журмыг нэгдүгээр хавсралтаар, "Сумын аварга малчин" шалгаруулах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Журмын дагуу хүлээн авч Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Хөдөө аж ахуйн тасагт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Б.БАТ-АМГАЛАН

642301022

Сумын Засаг даргын 2023 оны
11 дүгээр сарын 03-ний өдрийн
А/28 дугаар захирамжийн 1-р хавсралт



СУМЫН ШИЛДЭГ ХОТ АЙЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, малын чанарыг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, мал сүргээ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулан эрүүлжүүлэх болон нийгэмд оруулж байгаа малчдын хувь нэмрийг үнэлж, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Энэхүү журмын шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын ажлын үзүүлэлтийг нь үндэслэн "Сумын шилдэг хот айл"-аар шалгаруулна.

1.3."Сумын шилдэг хот айл"-аар шалгаруулах асуудлыг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн шалгуур үзүүлэлт хангасан малчдын материалыг Хөдөө аж ахуйн тасаг хүлээн авч, Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

Хоёр."Сумын шилдэг хот айл" шалгаруулахад тавигдах шалгуур үзүүлэлт.

2.1.Малын индексжүүлсэн даатгалд малаа хамруулж, малчин өрхийн гишүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 3-аас доошгүй жил төлсөн байх.

2.2.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний Календарчилсан төлөвлөгөөнд заасны дагуу тогтмол хамруулсан байх.

2.3.Мал эмнэлгийн үйлчилгээний лавлагааг нэгдсэн системээс татан авч мал эмнэлгийн улсын байцаагчаар баталгаажуулах.

2.4.Сүүлийн 3 жил өвөлжөө, хаваржаа, худаг усыг халдваргүйжүүлэлтэд хамруулсан байх.

2.5.Хоршоо бүлгийн зохион байгуулалтад нэгдэн хамтран ажилладаг байх.

2.6.Говийн бүсэд тогтоосон нормын дагуу хонин толгойд шилжүүлснээр 5 кг-аар тооцож, хадлан, гар тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх.

2.7.Тухайн малчин нь бэлчээр нутгийн маргаангүй малын тоо нь бэлчээрийн багтаамжаас хэтрээгүй, өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, гэрийн хашаа, малын хашаа, өвс тэжээлийн хашаа, 00, уст цэгтэй байх бөгөөд түүнийгээ засаж тохижуулдаг байх.

2.8.Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг хуваарийн дагуу ашиглах, отор хийх, сэлгэх, өнжөөх, зэргээр бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх.

2.9.Баг болон сум орон нутгаас зохион байгуулсан ажилд оролцсон байдал, нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн бүтээлч, үр дүнтэй ажил үйлчилгээ хийсэн байх.

2.10.Хамран сургах тойргийн ерөнхий боловсролын сургуульд (1-9 дүгээр анги), сургуулийн өмнөх боловсролд (5 настай хүүхдийг заавал) хүүхдээ бүрэн хамруулдаг байх.

2.11.Үндэсний товллолт дархлаажуулалтад 2 хүртлэх нас, 7, 15 насны хүүхдүүдээ бүрэн хамруулах

2.12.Угийн бичиг, зураглал хөтөлдөг байх.

2.13.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамрагдсан байх.

2.14. Мал аж ахуйн салбарт гэр бүлээрээ 5-аас дээш жил ажилласан байх.

2.15."Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод болон малын тэжээлийн ургамал тариалсан байх.

2.16.Айл өрх ахуйн хэрэглээнд хүнсний зориулалтын сав суулгыг хэрэглэж хэвшсэн байх.

2.17.Жил бүр хуулийн дагуу ногдсон албан татвар, төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлсэн байх.

2.18."Сумын шилдэг хот айл"-ын болзолыг хангаснаас хойш 2 жил хүртэлх хугацаанд "Сумын аварга малчин"-д тодорхойлох.

3.1.Жил бүр малчдын зөвлөгөөн болохоос өмнө ажлын 20 хоногийн дотор материалыг хүлээн авна.

3.2.Багуудаас хүлээн авсан материалыг ажлын 5 хоногийн дотор Сумын Засаг даргын дэргэдэх удирдлагын баг тухайн өрхийн аж байдалтай танилцан ажиллаж хэлэлцэн шийдвэрлэнэ.

Дөрөв.Бүрдүүлэх материал

4.1.БИНХ-аар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, Багийн Засаг даргын тодорхойлолт

4.2.Журмын заалтуудад холбогдох албан тушаалтнуудын тодорхойлолт, нотлох баримт бичиг, лавлагааг гаргаж өгөх.

4.3.Журамд заасан материалуудыг фото зургаар баталгаажуулсан байна.

Тав. Шалгаруулалт

5.1.Журмын шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын материалыг хянаж, харьцуулан, баллын системээр дүгнэж Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн шагнаж урамшуулах.

Зургаа. Шагналын сан

6.1."Сумын шилдэг хот айл" шагналын сан нь нийт 300,000 төгрөгийн үнэ бүхий зүйл, "Батламж" байна.

6.2.Шагналыг жил бүрийн малчдын зөвлөгөөнөөр гардуулах.

Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

Сумын Засаг даргын 2023 оны
11 дүгээр сарын 03-ний өдрийн
А/88 дугаар захирамжийн 2-р хавсралт

СУМЫН АВАРГА МАЛЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгох, малын чанарыг сайжруулах, нэг малаас авах тавиг шимийг нэмэгдүүлэх, мал сүргээ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулан эрүүлжүүлэх болон нийгэмд оруулж байгаа малчдын хувь нэмрийг үнэлж, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Энэхүү журмын шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын ажлын үзүүлэлтийг нь үндэслэн "Сумын аварга малчин"-аар шалгаруулна.

1.3."Сумын аварга малчин"-аар шалгаруулах асуудлыг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн шалгуур үзүүлэлт хангасан малчдын материалыг Хөдөө аж ахуйн тасаг хүлээн авч, Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

Хоёр."Сумын аварга малчин" шалгаруулахад тавигдах шалгуур үзүүлэлт.

2.1."Шилдэг хот айл" болзолыг хангасанаас хойш 2-оос доошгүй жил амжилттай ажилласан өрх сумын аварга малчинд нэр дэвшүүлнэ.

2.2.Мал сүргээ 3-аас дээш төрлөөр өсгөж, оны хээлтэгч тутмаас 100% төл бойжуулсан байна. Нийт мал сүргийн 20% нь бод, 35% нь хонь байна.

2.3.Сүрэгт эзлэх хээлтэгч мал нь бог малд 55, бод малд 40-өөс доошгүй хувьд хүрсэн эр, сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулдаг байх.

2.4.Малын индексжүүлсэн даатгалд малаа хамруулж, малчин өрхийн гишүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх.

2.5.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний Календарчилсан төлөвлөгөөнд хамруулах.

2.7.Сүүлийн 3 жил өвөлжөө, хаваржаа, худаг усыг халдваргүйжүүлэлтэд хамруулсан байх.

2.8.Хоршоо бүлгийн зохион байгуулалтад нэгдэн хамтран ажилладаг байх.

2.9.Тухайн бүс нутагт өсгөн үржүүлэхээр баталгаажсан үүлдэр, омог, хэвшлийн малаар малын чанараа сайжруулсан байх.

- 2.10. Говийн бүсэд тогтоосон нормын дагуу хонин толгойд шилжүүлсэнээр 5 кг-аар тооцож, хадлан, гар тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх.
- 2.11. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод болон малын тэжээлийн ургамал тариалсан байх.
- 2.12. Малын тоо толгойг тооцохдоо бусдаас худалдан авсан болон өр төлбөр, бэлгэнд авсан малыг оруулан тооцохгүй.
- 2.13. Тухайн малчин нь бэлчээр нутгийн маргаангүй малын тоо нь бэлчээрийн багтаамжаас хэтрээгүй, өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, гэрийн хашаа, малын хашаа, өвс тэжээлийн хашаа, 00, уст цэгтэй байх бөгөөд түүнийгээ засаж тохижуулдаг байх.
- 2.14. Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг хуваарийн дагуу ашиглах, отор хийх, сэлгэх, өнжөөх, зэргээр бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх.
- 2.15. Байгалийн эрсдэлийг даван туулахад ашиглах эрсдэлийн сан, хуримтлал бий болгосон байх. Сангийн доод хэмжээ 500,000 төгрөг байна.
- 2.16. Мал сүргээ бэлчээрийн даацад тохируулан эдийн засгийн эргэлтэд оруулан, өрхийн орлогоо нэмэгдүүлж, мал аж ахуйн материаллаг баазаа бэхжүүлэх, малын чанарыг сайжруулах, сурч боловсрох.
- 2.17. Нийгмийн хариуцлагын хүрээнд сум орон нутагт зохион байгууллагдаж буй олон нийтийг хамарсан арга хэмжээнд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг санаачилан хийж хэвшсэн байна.
- 2.18. Хамран сургах тойргийн ерөнхий боловсролын сургуульд (1-9 дүгээр анги), сургуулийн өмнөх боловсролд (5 настай хүүхдийг заавал) хүүхдээ бүрэн хамруулдаг байх. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамрагдсан байх.
- 2.18. Угийн бичиг, зураглал хөтөлдөг байх.
- 2.19. Улаан загалмайн нийгэмлэгийн гишүүн байх. (онцгой гишүүн байх)
- 2.20. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамрагдсан байх.
- 2.21. Үндэсний товлотт дархлаажуулалтад 2 хүртлэх нас, 7, 15 насны хүүхдүүдээ бүрэн хамруулах
- 2.22. Амьдралын түвшин доогуур орлоготой малчин өрхийг 20-оос доошгүй малаар малжуулсан байх.
- 2.23. Ердийн унаа, хөсөг хэрэглэдэг байхын зэрэгцээ мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулж, амьдрал ахуйдаа хэрэглэж хэвшсэн байх (эсгий хийх, сур элдэх, арьс нэхий элдэх, хөхүүр сав хэрэглэх)
- 2.24. Айл өрх ахуйн хэрэглээнд хүнсний зориулалтын сав суулгыг хэрэглэж хэвшсэн байх.

2.25. Жил бүр хуулийн дагуу ногдсон албан татвар, төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлсэн байх.

2.26. Баг тус бүрээс 1-2 малчны материалыг бэлтгэн оруулах.

2.27. "Сумын аварга малчин"-ы болзлыг хангасанаас хойш 3-аас доошгүй жил хурт хугацаанд "Аймгийн аварга малчин"-д тодорхойлох.

Гурав. Хугацаа

3.1. Жил бүр малчдын зөвлөгөөн болохоос өмнө ажлын 20 хоногийн дотор материалыг хүлээн авах.

3.2. Багуудаас хүлээн авсан материалыг ажлын 5 хоногийн дотор Сумын Засаг даргын дэргэдэх удирдлагын баг тухайн өрхийн аж байдалтай танилцан ажиллаж хэлэлцэн шийдвэрлэнэ.

Дөрөв. Бүрдүүлэх материал

4.1. БИНХ-аар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, Багийн Засаг даргын тодорхойлолт

4.2. Журмын заалтуудад холбогдох албан тушаалтнуудын тодохойлолт, нотлох баримт бичиг.

4.3. Малчны (нөхөр, эхнэрийн) товч анкет

4.4. Ажлын үзүүлэлт

4.5. Иргэний үнэмлэхний хуулбар

4.6. Малын А дансны хуулга сүүлийн 3 жилээр

4.7. "Сумын шилдэг хот айл" батламжны хуулбар

4.8. Ажил байдлын тодорхойлолт

4.9. Журамд заасан материалуудыг фото зургаар баталгаажуулсан байна.

Тав. Шалгаруулалт

5.1. Журмын шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын материалыг хянаж, харьцуулан, баллын системээр дүгнэж, 5-8 малчныг Засаг даргын дэргэдэх удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрээр шагнаж урамшуулах.

Зургаа. Шагналын сан

6.1. "Сумын аварга малчин" шагналын сан нь нийт 500,000 төгрөгийн үнэ бүхий зүйл, "Батламж", тууз, энгэрийн тэмдэг байна.

6.2. Шагналыг жил бүрийн малчдын зөвлөгөөнөөр гардуулах.

Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.